



# ХАРХОРИН ХУВЬЦААТ КОМПАНИ

2017 ОНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



### **1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:**

Хархорин ХК

Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ-толгой баг, Усжуулахын контор

Утас: 70327890

Факс: 70151955

Электрон хаяг: [kh.kh\\_jsc@yahoo.com](mailto:kh.kh_jsc@yahoo.com)

### **2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:**

1.	Оноосон нэр	Хархорин
2.	Хариуцлагын хэлбэр	Нээлттэй Хувьцаат Компани
3.	Регистрийн дугаар	2015471
4.	Улсын бүртгэлийн дугаар	1010001006
5.	Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.29
6.	Үндсэн эрхлэх үйл ажиллагаа	Чацаргана тариалах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх

### **3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:**

Үнэт цаас гаргагчийн зорилго: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт тэргүүлэгч, чацаргана тариалагч, чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болох.

Үйл ажиллагааны стратеги: “Хархорин” ХК нь Монгол Улсад төдийгүй дэлхийд томоохонд орох нийт 3,000 гаруй га талбай бүхий чацарганы “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнээс 2007 – 2017 онд нийт 600 гаруй га талбайд чацаргана тариалаад байгаа бөгөөд чацарганы ургацын хэмжээ жил тутам нэмэгдэж байна.

### **4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:**

Тус “Хархорин” ХК нь Монгол Улсын эртний нийслэл Хархорин хот, одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэтолгой багийн нутаг дэвсгэрт байрлаж байна. Хархорин сум нь Улаанбаатар хотоос баруун тийш 360 км, Өвөрхангай аймгаас зүүн хойш 130 км зайд оршдог.

Хархорин ХК нь анх 1956 онд БНМАУ-ын Засгийн газрын 100% хөрөнгө оруулалтаар Хархорин сум САА нэртэйгээр газар тариалан, мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй Монголын томоохон САА нэг юм. 1990 онд Монгол оронд Ардчилсан хувьсгал гарч ирсэнээр 1992 онд тус САА нь Хархорин ХК нэртэйгээр төрийн өмч хувийн өмчид шилжин 70% төр, 30% тухайн нутгийн ард иргэдэд өмчлөн холимог

системээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1992 оноос тус компанийн хэвийн ажиллагаа доголдож 2007 онд өмч хувьчлал буюу нээлттэй тендэр зарлан 100%, хувийн өмчид шилжсэн. Шилжсэн цагаас хойш тус компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн Монгол Улсын засгийн газраас баталсан “Чацаргана”, “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд, чацаргана үржүүлэх, тариалах чиглэлээр нийт 200 гаруй ажилтан албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь Ерөнхий агрономич Л.Бямбасүрэнгээр ахлуулсан 6 бригад, бригадыг ахалсан мэргэжлийн 6 агрономичтойгоор агроүйлдвэрлэл явуулж байна. Компанийн эзэмшлийн газар нутгийн хувьд 4000 гаруй га талбай, Орхон голоос эх авсан усалтын 13 м сувагтай 2007 оноос эдүүгээ нийт 600 гаруй га талбайд чацарганы жимст цэцэрлэг байгуулах ажлыг амжилттай байгуулан ажиллаж байна. Мөн 2014 он ОХУ-аас гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, алим гэх мэт төрлийн жимслэг ургамлыг нутагшуулах ажлыг зохион байгуулж байна.

“Хархорин” ХК нь Монгол Улсад хамгийн томд орох таримал чацарганы талбайтай бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажилласан тохиолдолд жилд нийт 2,000 гаруй тонн чацарганы жимс хураан авч дотоодын чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх хүчин чадалтай.

Монголын Чацарганы холбооноос авсан мэдээллээр одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 40 гаруй том жижиг чацаргана боловсруулах үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрийн нийт хүчин чадлын хэмжээ нь жилд 5,000 орчин тонн түүхий чацаргана боловсруулах боломжтой. Үүнээс үзвэл “Хархорин” ХК нь дангаараа Монгол Улсын чацаргана боловсруулах үйлдвэрүүдийн нэг жилийн түүхий эдийн хэрэгцээний 40%-ийг хангах бололцоотой.

#### **5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:**

Тайлант хугацаанд “Хархорин” ХК-ийн бараа бүтээгдэхүүний гол зах зээл болох жимс, жимсгэнэ, тэр дундаа чацарганы дотоод болон гадаад зах зээлд томоохон өөрчлөлт гараагүй болно.

Харин 2017 оны зун манай улсын газар тариалангийн бүс нутгуудаар бороо хур бага, ихээр халж, хуурайшилт ихтэй байсан. Энэ нь зөвхөн манай төдийгүй Монгол Улсын бусад чацаргана тариалагч иргэд, ААН-үүдийн ургац хураалтад муугаар нөлөөлж 2017 оны дүнгээр улсын хэмжээнд чацарганы ургац муу байсан. Үүнээс үүдэн улсын хэмжээгээр 2017 оны эцсээр чацарганы түүхий жимсний нийлүүлэт бага, эрэлт өндөр байсан тул чацаргана жимсний үнэ нэмэгдэх гол шалтгаан болсон. Ургац сайн байсан 2016 онд чацаргана жимсний бөөний үнэ Улаанбаатар хотод 2500 төг/кг болж буурч байсан бол 2017-2018 оны өвөл чацаргана жимсний хэрэглээ хамгийн их байдаг үед кг-ийн үнэ 6000 төгрөгт хүрсэн.

“Хархорин” ХК-ийн хувьд чацарганы тариалангийн талбай нь халиа усалгаатай. Бороо хур багатай, хуурайшилт ихтэй үед дан халиа усалгаагаар чацарганы моднуудад хангалттай сайн усалгаа хийх боломжгүй байдаг тул 2017 онд жимсний гарц муу байсан.

2017 онд нийт хураасан чацарганы жимс болон бусад бүтээгдэхүүний нарийвчилсан тооцоог энэхүү тайланд тусгасан байгаа.

**6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга:**

<b>П.Бишрэл</b>	<b>ТУЗ-ийн Дарга</b>
<b>Л.Хосбаяр</b>	ТУЗ-ийн ердийн гишүүн
<b>О.Төмөрбаатар</b>	ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин, урамшууллын хорооны дарга
<b>Ц.Энх-Амгалан</b>	ТУЗ-ийн ердийн гишүүн, Аудитын хорооны гишүүн
<b>Ж.Энхтөр</b>	ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга
<b>П.Учрал</b>	ТУЗ-ийн ердийн гишүүн
<b>Б.Амарсанаа</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
<b>С.Амгалан</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
<b>Б.Бүрэн</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх болон Цалин, урамшууллын хороодын гишүүн
<b>Р.Саранцэцэг</b>	Гүйцэтгэх захирал
<b>Б.Ганбат</b>	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
<b>Д.Дашмаа</b>	Ерөнхий нягтлан бодогч

**7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:**

<b>Д.д</b>	<b>Хувьцаа эзэмшигчийн овог, нэр</b>	<b>Эзэмшиж байгаа хувьцааны тоо</b>	<b>Эзлэх хувь</b>
<b>1</b>	Сүрэнжавын Пүрэв	377,660	70.0%
<b>2</b>	Лхагвасүрэнгийн Хосбаяр	101,634	18.8%

## **8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт (2017 жилийн эцсийн байдлаар)**

Үнэт цаас гаргагч нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2017.01.01-с 2017.12.31-ний тайлант хугацаанд өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид нь “Хархорин” ХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

“Хархорин” ХК-ийн 2016 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт хөрөнгө 7,554.8 сая.төг байсан бол 2017 оны 12-р сарын 31-ны байдлаар 8,279.8 сая төгрөг болж 9.6% өссөн үзүүлэлттэй байна.

2017 оны жилийн эцсийн тайлангаар нийт үндсэн хөрөнгө элэгдэл хассан дүнгээр 1,660,432 мянган төгрөг, түүнчлэн биологийн хөрөнгө 1,082,788 мян.төг байна.

2017 оны жилийн эцсээр мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө 2,077 мян.төг, авлагын нийт дүн 1,731,271.8, бараа материал нийт 552,451.8 мян.төг, дуусаагүй үйлдвэрлэл 1,953,901 мян.төг, бусад санхүүгийн хөрөнгө 1,296,918 мян.төг байна.

Урт болон богино хугацаат өр төлбөр: 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу “Хархорин” ХК нь нийт 1,890,000 мян.төг-ийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй, богино хугацаат өр төлбөр 6,832,139 мян.төг, нийт 8,722,139 мян.төг-ийн өр төлбөртэй гэж гарсан.

Үр дүнгийн тооцоо

Тайлант хугацаанд: Борлуулалтын нийт орлого:	1,219,794 мян.төг;
Борлуулалтын өртөг:	975,971 мян.төг;
Борлуулалтын ашиг:	243,823 мян.төг;
Үйл ажиллагааны бус орлого:	97,345 мян.төг;
Ерөнхий ба удирдлагын зардал:	210,619 мян.төг;
Бусад зардал:	93,752 мян.төг

болж тайлант үеийн цэвэр ашиг татвар төлөхийн өмнөх байдлаар 36,797 мян.төг болсон. Үүнээс орлогын албан татварын зардал 3,197 мян.төг-г хасаад тайлант үеийн цэвэр ашиг татварын дараах дүнгээр 33,600 мян.төг болсон.

### **“Хархорин” ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн тухай**

Компани нь 2017 оны 02-р сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурлаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын компани болох “Улиастай Ван Аудит” ХХК-ийг аудиторoor сонгосон. Тус аудитын компаниар бид 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн болно. Аудитын дүгнэлтийг дараах хуудаснаас үзнэ үү:

“УЛИАСТАЙ ВАН –АУДИТ”

ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл,  
санхүүгийн зөвлөгөө, сургалтын  
итгэмжлэгдсэн байгууллага



“ULIASTAI VAN-AUDIT”

LLC

Auditing, Accounting,  
Consulting and Training

20.18 оны 03 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 113/18

Улаанбаатар хот.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“ХАРХОРИН” ХК-ийн  
УДИРДЛАГАД

Бид “ХАР ХОРИН” ХК-ны (шашид “Компани” гэх) 2017 оны 12 дугаар сарын 31-ны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

**Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

**Аудиторын үүрэг хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгосон бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцоололыг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдах ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт найдаж байна.

**Хэрэглээний хязгаарлалт**


Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэг өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

**Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан**

Түүнчлэн, санхүүгийн тайлан бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн журам, заавартай нийцэж байна.



Чингэлтэй дүүрэг, 3-р хороо  
Энхтайвны өргөн чөлөө  
CANON тов, 6 давхар, 602 тоот



Утас: 70157405, 99097405, 96696399  
Мэйл хаяг: uliastaiivanaudit@gmail.com  
Веб хуудас: ubaudit.mn  
Улаанбаатар Монгол улс

"ХАР ХОРИН" ХК  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи  
Санхүүгийн байдлын тайлан

	(мянган төгрөг)	
	2016.12.31	2017.12.31
<b>Хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	1,865	2,077
Дансны авлага	1,300,939	1,462,622
Бусад авлага	268,650	268,650
Бусад санхүүгийн хөрөнгө	1,296,918	1,296,918
Бараа материал	460,570	552,452
Бусад эргэлтийн хөрөнгө	1,399,079	1,953,901
Үндсэн хөрөнгө	1,743,965	1,660,432
Бусад эргэлтийн хөрөнгө	1,082,788	1,082,788
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>7,554,775</b>	<b>8,279,839</b>
Дансны өглөг	5,390,660	5,412,655
Цалингийн өглөг	41,450	72,511
Татварын өр	8,996	33,523
НДШ өр	2,490	6,460
Богино хугацаат зээл	18,000	1,177,983
Хүүний өглөг		129,007
Урьдчилж орсон орлого	49,078	
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,510,674</b>	<b>6,832,139</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл	2,520,000	1,890,000
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,520,000</b>	<b>1,890,000</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>8,030,674</b>	<b>8,722,139</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>		
Өмч /хувийн/	836,220	836,220
Хуримтлагдсан ашиг алдагдал	(1,312,120)	(1,278,520)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>(475,900)</b>	<b>(442,300)</b>
<b>Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>7,554,775</b>	<b>8,279,839</b>

"ХАР ХОРИН" ХК

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Дэлгэрэнгүй орлогын тайлан

	(мянган төгрөг)	
	2016.12.31	2017.12.31
Борлуулалтын орлого	2,078,007	1,219,794
Борлуулалтын өртөг	1,999,145	975,971
<b>Нийт ашиг, (алдагдал)</b>	<b>78,861</b>	<b>243,823</b>
Бусад орлого	149,748	97,345
Ерөнхий ба удирдлагын зардал	214,981	210,619
Бусад зардал		93,752
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал</b>	<b>13,628</b>	<b>36,797</b>
Орлогын албан татварын зардал	341	3,197
<b>Татварын дараах ашиг, алдагдал</b>	<b>13,288</b>	<b>33,600</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал</b>	<b>13,288</b>	<b>33,600</b>
<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>13,288</b>	<b>33,600</b>

"ХАР ХОРИН" ХК

2017 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Өмчийн өөрчлөлтийн тайлан

	(мянган төгрөг)				
	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (аллагдал)	Өмчийн дүн
<b>2015 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>836,220</b>			<b>(1,312,120)</b>	<b>(475,899)</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (аллагдал)					-
Хуваарилсан ногдол ашиг					-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг					-
<b>2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>836,220</b>	-	-	<b>(1,312,120)</b>	<b>(475,899)</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (аллагдал)				33,600	33,600
Зарласан ногдол ашиг					-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг					-
<b>2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>836,220</b>	-	-	<b>(1,278,520)</b>	<b>(442,300)</b>



**"ХАР ХОРИН" ХК**  
2017 оны 12 дугаар дугаар 31 -ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Өмчийн өөрчлөлтийн тайлан

	(мянган төгрөг)				
	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (аллагдал)	Өмчийн дүн
<b>2015 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	836,220			(1,312,120)	(475,899)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (аллагдал)					-
Хуваарилсан ногдол ашиг					-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг					-
<b>2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	836,220	-	-	(1,312,120)	(475,899)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (аллагдал)				33,600	33,600
Зарласан ногдол ашиг					-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг					-
<b>2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	836,220	-	-	(1,278,520)	(442,300)

### 8.3. Татварын тайлангийн тухай (2017 оны жилийн эцсийн байдлаар):

“Хархорин” ХК нь 2017 оны 01-04 дүгээрр улирлын татварын тайлангуудаа Монгол улсын Татварын багц хууль, тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд гаргаж цахимаар харъяа татварын байгууллагад илгээж баталгаажуулсан болно.

### 9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл

Тайлант хугацаанд буюу 2017 оны 01-р сарын 31-с 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд “Хархорин” ХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох аливаа гэрээ, хэлцэл байгуулаагүй болно.

### 10. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл

Энэ онд “Хархорин” ХК чацаргана тариалж эхлэсний 10 жилийн ой тохиож байгаа бөгөөд бид өмнөх жилүүдийнхээ ургацыг ахиулан илүү их ургац хураан авах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

2017 оны 4 сард компаний ажиллах хүчнийг залуужуулж, орон тоог нэмэгдүүлэх зорилгоор Хархорин суманд болон Өвөрхангай аймагт “Ажлын байрны нээлттэй хаалганы өдөрлөг” танилцуулах уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж ажилласан. Шинэ ажлийн байранд 40 гаруй ажилтан албан хаагчдыг шинээр авч ажиллуулж байна.

2017 оны 03 сараас эхлэн усалгааны суваг шуудууны тоног төхөөрөмжийг засаж сэлбэх, өөрөө явдаг болон дүүжин, чиргүүлэн машин техник, тоноглолийг өвлийн тэг зогсолтоос гаргаж засварлахын тулд усалгааны бригадыг болон мех баазын механикжуулагчдыг ажилд нь оруулан засварын ажлуудыг хийлгэсэн.

Компанийн газар тариалангийн болон жимст цэцэрлэгийн талбайн ажил 2017 оны 4 сараас эхлэн одоог хүртэл гүйцэтгэл сайтай явагдаж байна.

2017 оны 5 сараас эхлэн чацаргана, хайлаас, шар хуайс болон бусад модны суулгац гаргаж эхэлсэн. Оны эхний хагасын хугацаанд гадны байгууллага хувь хүмүүст 61,320 ширхэг чацарганы, 32,000 ширхэг хайлаасны, 210 ширхэг үхрийн нүдний, 110 ширхэг улиасны, 120 ширхэг шар хуайсны зэрэг суулгацуудыг зарж борлуулсан.

2017 оны 4 сарын 27-нд Булган аймгийн төв Булган хотод зохион байгуулагдсан аймгийн үзэсгэлэн худалдаа, 2017 оны 5-р сарын 11-нд Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотод зохион байгуулагдсан аймгийн үзэсгэлэн худалдаануудад компанийн зүгээс идэвхитэй оролцон олон төрлийн модны суулгац зарж борлуулахаас гадна компаниа сурталчилах ажил хийгдсэн.

2017 оны 5 сард Булган аймгийн Засаг даргын тамгын газраас зарласан чацаргана жимсний суулгац нийлүүлэх тендерт оролцож 3, 4-р багцад шалгарч 194 мянган ширхэг суулгац нийлүүлэхээр болсон. Үүнээс захиалагч талын хүсэлтээр хавар 40 хувийг буюу 77.5 мян. ширхэг, намар 60 хувийг буюу 116.3 мян. ширхэг суулгац нийлүүлэхээр гэрээ байгуулан, гэрээт үүргээ хуваарийн дагуу биелүүлж байгаа болно.

2017 оны 6-р сард ХХААХҮ-ийн яамнаас зарласан “Байгалийн эрсдэлд өртөмтгий аймгуудад уурагт таримал тэжээлийн нөөц нэмэгдүүлэх” төсөл сонгон шалгаруулалтанд оролцсон.

Гүйцэтгэх захирлын хувьд компанийг өдөр тутмын шуурхай удирдлагаар байнга ханган, тулгамдсан асуудлуудыг богино хугацаанд шийдвэрлэн ажиллаж байгаа болно.

### **2017 онд “Хархорин” ХК-ийн Чацарганы жимст цэцэрлэгийн талбайд хийгдсэн ажлын тайлан**

2017 оны 01-р сарын 05-наас 02-р сарын 05-ны хооронд өмнөх 2016 оны талбайд үлдсэн чацарганы жимсний ургацыг 1-р бригадын 166 хүн/өдөр хүчээр 11323,9 кг, 2-р бригадын 122 хүн/өдөр хүчээр 8892,9 кг, 3-р бригадын 84 хүн/өдөр хүчээр 4537,6 кг, 4-р бригадын 156 хүн/өдөр хүчээр 8821 кг, 5-р бригадын 118 хүн/өдөр хүчээр 6018,6 кг, буюу нийт дүнгээрээ 646 хүн/өдөр хүчээр нийт 40 гаруй тонн чацарганы жимсийг доргиох аргаар хураан авсан.

Мөн 2017 оны 01-р сард жимст цэцэрлэгийн талбайн жимст моддод таналт хийсэн ба үүнд 1-р бригадын 31 хүн/өдөр хүч ашиглан 8554 ширхэг модонд, 4-р бригадын 31 хүн/өдөр хүч ашиглан 6279 ширхэг модонд, 5-р бригадын 16 хүн/өдөр хүч ашиглан 2905 ширхэг модонд, буюу нийт дүнгээрээ 78 хүн/өдөр хүч ашиглан 17738 ширхэг модонд таналт хийлгэсэн.

2017 оны 01-р сард бойжуулгын талбайн 37 мөр услалтын системтэй талбайд таналт хийлгэсэн ба үүнд 1-р бригадын 39,5 хүн/өдөр хүч зарцуулан 1787 метр урт, 2-р бригадын 35 хүн/өдөр хүч зарцуулан 2200 метр урт, 3-р бригадын 22 хүн/өдөр хүч зарцуулан 1500 метр урт, 4-р бригадын 46 хүн/өдөр хүч зарцуулан 1229,7 метр урт, 5-р бригадын 20 хүн/өдөр хүч зарцуулан 510 метр урт буюу нийт дүнгээрээ 518 хүн/өдөр хүч ашиглан 7226,7 метр урт суулгац тариалсан мөрөнд таналт хийлгэсэн.

Таналт хийгдсэн талбайгаас танасан мөчир, цуглуулж тракторт ачин талбайгаас гарган буулгах ажилд 1-р бригадын 2,5 хүн/өдөр хүч ашиглаж тракторын 11 тэвш, 2-р бригадын 2,8 хүн/өдөр хүч ашигласан ба тракторын 5,6 тэвш, 3-р бригадын 0,5 хүн/өдөр хүч ашигласан ба тракторын 0,5 тэвш, 4-р бригадын 1 хүн/өдөр хүч ашигласан ба тракторын 5 тэвш буюу нийт дүнгээрээ 6,8 хүн/өдөр хүч ашигласан ба тракторын 22,1 тэвш танасан иш мөчрийг талбайгаас тракторт ачин талбайгаас гаргаж буулгасан.

2017 оны 01 сард хайрцагтай суулгацанд мөн таналт хийлгэсэн ба энэ ажилд 2-р бригадын 17 хүн/өдөр хүч зарцуулан 69 хайрцаг, 3-р бригадын 9,6 хүн/өдөр хүч зарцуулан 30 хайрцаг буюу нийт дүнгээрээ 26,6 хүн/өдөр хүч зарцуулан 95,6 хайрцагтай хөгшин суулгацыг танасан.

2017 оны 04 сарын 17-ны өдөр жимст цэцэрлэг хариуцсан цэцэрлэгчдийн хүчээр сувгийн цэвэрлэгээг хийж эхлэсэнээр энэ жилийн жимст цэцэрлэгийн талбайн ажил эхлэсэн. Энэ ажилд 1-р бригад 14 хүн/өдөр, 2-р бригад 16 хүн/өдөр, 3-р бригад 8 хүн/өдөр, 4-р бригад 16 хүн/өдөр, ойн зурвас хариуцсан 5-р бригад 7 хүн/өдөр буюу нийтдээ 61 хүн/өдөр хүчээр 4-р сарын 17-нд сувагт 2016 оны үерээр шороо орсон хэсгүүдээс шороог нь гаргах, мөн сувгийн хөнгөн хогийг бөөгнүүлэн авч самосвалд ачиж хогийн цэгт аваачиж асгасан.

04-р сард нэгээс хоёр өдрийн хугацаанд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчээр жимст цэцэрлэгийн ба тариан талбайн хог цэвэрлэгээ, труба ачиж буулгах, хөргөгч угаах, тогооч хийх зэрэг аж ахуйн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн 04-р сард 2-р бригадын 15,5 хүн/өдөр хүчээр хайрцаг хийх талбайг чиг гаргаж хуваах, суулгацыг ялгаж тоолж ангилаад түр хадгалж, шошго зүүгээд боож ачих ажил хийлгэсэн. 3-р бригадын 3 хүн/өдөр хүчээр 1А дугаартай талбайд трактороор чиг бариулан шуудуу гаргуулаад 5,5 хүн/өдөр хүчээр 3340 м урт трактороор гаргасан шуудууг гараар засуулаад мөн 5,5 хүн/өдөр хүчээр 1731 модны нүх ухуулсан. 4-р бригадын 18,3 хүн өдөр хүчээр 8443 м урт трактороор татуулсан шуудууг гараар засуулаад 2,6 хүн өдөр хүчээр 1520 ширхэг модны нүх ухуулаад 2,8 хүн өдөр хүчээр 700 ширхг чацарганы модыг нөхөн тариалсан. Нөхөн тариалсан болон нөхөлт хийгдээгүй

бусад нийт талбайд 4-р бригадын 49 хүн өдөр хүчээр 14050 м урт усалгааны туслах шуудууг гараар ухаж сэргээн засаад 46 хүн өдөр хүчээр 59610 м урт усалгааны шуудуугаар усалгаа хийсэн.

04-р сард бойжуулгын талбайд тарьц тариалах хайрцаг хийх ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчийг ашигласан ба энэ ажилд 1-р бригадын 63 хүн/өдөр хүн/өдөр хүчээр 482 хайрцагийг, 2-р бригад 67 хүн/өдөр хүчээр 476,5 хайрцагийг, 3-р бригад 40,5 хүн/өдөр хүн/өдөр хүчээр 401 хайрцагийг, 4-р бригад 9 хүн/өдөр хүн/өдөр хүчээр 63 хайрцагийг буюу нийтдээ 179,5 хүн/өдөр хүн/өдөр хүчээр 1422,5 хайрцагийг шинээр хийсэн.

04-р сард хүлэмжнээс тарьц гараар ухаж гаргах ажилд 2-р бригадын 99,5 хүн өдөр хүч зарцуулан 520231 ширхэг тарьцыг чацарганы ногоон мөчир тариалсан 20 хүлэмжнээс ухаж гарган тариалалт хийж буй бригадуудад нийлүүлж тариалалт хийлгэсэн.

04-р сард бойжуулгын талбайн хайрцагт тарьц тариалах ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчийг ашигласан ба энэ ажилд 1-р бригадын 92 хүн/өдөр хүчээр 421 хайрцагт 234094 ширхэг тарьцыг, 2-р бригад 3,5 хүн/өдөр хүчээр 22,5 хайрцагт 7513 ширхэг тарьцыг, 3-р бригад 69,5 хүн/өдөр хүчээр 325 хайрцагт 151601 ширхэг тарьцыг, 4-р бригад 25,5 хүн/өдөр хүчээр 153,5 хайрцагт 70552 ширхэг тарьцыг буюу нийтдээ 190,5 хүн/өдөр хүчээр 922 хайрцагт 463760 ширхэг тарьцыг тариалсан. Тарьц тариалсан хайрцаг услах ажилд 1-р бригадын 11 хүн/өдөр хүчээр 421 хайрцагийг, 2-р бригад 3 хүн/өдөр хүчээр 110 хайрцагийг, 3-р бригад 11 хүн/өдөр хүчээр 325 хайрцагийг, 4-р бригад 3,5 хүн/өдөр хүчээр 154 хайрцагийг буюу нийтдээ 28,5 хүн/өдөр хүн/өдөр хүчээр 1010 хайрцагийг усалсан.

04-р сард нийт жимст цэцэрлэгийн талбайн шижим устгах ажилд 1-р бригад 25 хүн/өдөрт 44650 м урт мөрний, 4-р бригад 81 хүн/өдөрт 114180 м урт мөрний буюу нийтдээ 106 хүн/өдөр хүч зарцуулан 158830 м урт мөрний шижим устгасан.

Эх цэцэрлэгийн талбайн 10750 м урт өргөн мөрний өмнөх жилийн борог өвсийг авах ажилд 2-р бригадын 20 хүн өдөр хүчийг зарцуулсан.

04-р сард ойн 5-р бригадын 32,2 хүн өдөр хүчээр ойн зурвасын 6278 ширхэг модны нүх ухаад, 27,8 хүн өдөр хүчээр 3983 ширхэг улиас, хайлаасыг ойн зурваст нөхөн тариалж, 24,6 хүн өдөр хүч зарцуулан 4162 ширхэг ойн зурвасын модыг 50 м хүртэлх зайд хувингаар ус зөөж, 10 хүн өдөр хүч зарцуулан 13934 ширхэг модыг тракторын араас дагаж шалангаар тус тус усалсан. 4-р бригадын 3 хүн/өдөр хүчээр 700 ширхэг суулгацыг жимст цэцэрлэгт нөхөн тариалж, 04-р сард жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчээр талбайн нөхөн тариалалтын ба тендерийн суулгац гаргах ажилд 1-р бригад 10 хүн/өдөр хүчээр 5980 ширхэг суулгацыг 25 хайрцагнаас, 2-р бригад 10 хүн/өдөр хүчээр 10189 ширхэг суулгацыг 59,4 хайрцагнаас, Ойн 5-р бригад 17,5 хүн/өдөр хүчээр 4954 ширхэг суулгацыг 21,6 хайрцагнаас, буюу нийтдээ 37,5 хүн/өдөр хүчээр 21123 ширхэг суулгацыг 106 хайрцагнаас ухаж гарган нийлүүлсэн.

05-р сард хөргөгч суллах, тогооч хийх, труба зөөж, буулгах, бордоо ачиж, буулгах, будаа цэнэглэх зэрэг аж ахуйн ажилд 1-р бригад 47 хүн/өдөр, 2-р бригад 11,5 хүн/өдөр, 3-р бригад 21 хүн/өдөр, 4-р бригад 13,5 хүн/өдөр, ойн 5-р бригад 39,5 хүн/өдөр буюу нийтдээ 132,5 хүн/өдөр хүч зарцуулсан.

05-р сард жимслэгч чацарганы модонд тоос хүртээх, хайлаас түүх, суулгацыг түр хадгалалтанд оруулах, түр хадгалалтаас ухаж гарган ялган тоолж ангилаад, шошго зүүн боож ачих, мод тоолох, олон төрлийн модны хучлага авах, гүзээлзгэний арчилгаа, хор цацалт, усалгаа, олон төрлийн модны тогооны сийрүүлэлт хийх, Ротарийн хүлэмжинд хүлэмж хучих, хүлэмжний засвар үйлчилгээ хийх мотор систем угсрах, хүлэмж хучих, хүлэмжний усалгаа хийх зэрэг цагийн ажилд 1-р бригадын 112,4 хүн өдөр хүч, 2-р бригадын 255 хүн өдөр хүч, 3-р бригадын 54 хүн өдөр хүч, 4-р бригадын 180 хүн өдөр хүч, ойн 5-р бригадын 31 хүн өдөр хүч буюу нийт дүнгээрээ 632,4 хүн өдөр хүч зарцуулсан.

05-р сард 1-р бригадын 21 хүн өдөр хүчээр 4740 м урт трактороор гаргасан шуудууг гараар засуулаад, 270 хүн өдөр хүчээр нөхөн тариалсан болон нөхөлт хийгдээгүй талбайд 326281 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийсэн.

05-р сард бойжуулгын талбайд тарьц тариалах хайрцаг хийх ажилд 1-р бригадын 16,4 хүн/өдөр хүчээр 95 хайрцагийг, 2-р бригад 4,5 хүн/өдөр хүчээр 36 хайрцагийг, 3-р бригад 3 хүн/өдөр хүчээр 7,5 хайрцагийг, 4-р бригад 6,4 хүн/өдөр хүчээр 55 хайрцагийг буюу нийтдээ 31 хүн/өдөр хүн/өдөр хүчээр 193,5 хайрцагийг шинээр хийсэн.

05-р сард хүлэмжнээс тарьц гараар ухаж гаргах ажилд 1-р бригадын 1 хүн өдөр хүч зарцуулан 5000 ширхэг тарьцыг, 2-р бригадын 37,5 хүн өдөр хүч зарцуулан 165142 ширхэг тарьцыг буюу нийт дүнгээрээ 38,5 хүн өдөр хүч зарцуулан 170142 ширхэг чацарганы ногоон мөчрийн тарьцыг ухаж гарган тариалалт хийж буй бригадуудад нийлүүлж тариалалт хийлгэсэн.

05-р сард бойжуулгын талбайн хайрцагт тарьц тариалах ажилд 1-р бригадын 69 хүн/өдөр хүчээр 271,4 хайрцагт 124881 ширхэг тарьцыг, 2-р бригад 30 хүн/өдөр хүчээр 78 хайрцагт 24970 ширхэг тарьцыг, 3-р бригад 22 хүн/өдөр хүчээр 103 хайрцагт 56290 ширхэг тарьцыг, 4-р бригад 18 хүн/өдөр хүчээр 92 хайрцагт 43194 ширхэг тарьцыг буюу нийтдээ 139 хүн/өдөр хүчээр 544,4 хайрцагт 249335 ширхэг тарьцыг тариалсан. Тарьц тариалсан хайрцаг услах ажилд 1-р бригадын 6 хүн/өдөр хүчээр 267 хайрцагийг, 2-р бригад шинээр тариалсан ба хуучин тариалсан байсан 3420 хайрцагийг 59 хүн/өдөр хүчээр, 4-р бригад 2 хүн/өдөр хүчээр 88 хайрцагийг буюу нийтдээ 67 хүн/өдөр хүн/өдөр хүчээр 3775 хайрцагийг усалсан.

05-р сард 1-р бригадын 9,5 хүн/өдөр хүчээр 442 ширхэг үхэр нүдний том моддыг 11А талбайгаас эксковатор ашиглан ухаж гаргаад пад трактор ашиглан үхэр нүдний 19Б, 22Б талбайнуудад нөхөн тариалалтын 60 см X 60 см X 80 см хэмжээтэй нүх ухаад 9,5 хүн/өдөр хүч зарцуулан тариалж усалсан.

05-р сард 2-р бригадын 6 хүн өдөр хүн хүчээр 1Б талбайд 1504 ширхэг чацарганы сортын мод тариалах нүх ухаж сортын суулгацыг мөн хүн хүчээр тариалж 31,5 хүн өдөр хүн хүчээр 13000 м урт усалгааны туслах шуудууг гараар засварлан ухаж гаргаад 50 хүн өдөр хүчээр 66600 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийсэн. Мөн 2-р бригадын 10,5 хүн өдөр хүчээр олон төрлийн жимсний 3784 модыг усалсан. 3-р бригадын 26 хүн өдөр хүчээр 10209 м урт усалгааны туслах шуудууг гараар ухаж гаргаад 100 хүн өдөр хүчээр 122398 м урт усалгааны шуудуугаар жимст цэцэрлэгт усалгаа хийлгэсэн. 4-р бригадын 25 хүн өдөр хүн хүчээр 8332 нөхөн тариалалтын модны нүх ухаад, 22 хүн өдөр хүчээр тариалат хийсэн. Нөхөн тариалалт хийсэн ба хийгээгүй 135 хүн өдөр хүчээр 159874 м урт усалгааны шуудуугаар 1-р усалгаа хийсэн. Тус бригадын 22 хүн өдөр хүчээр трактороор татсан 14190 м урт усалгааны туслах шуудууг, 87 хүн өдөр хүчээр 27595 м урт усалгааны туслах шуудууг гараар татаж усалгаа хийсэн. Мөн 4-р бригад 52 хүн өдөр хүчээр 17453 модонд үзлэг хийж хатсан ба шимэгч мөчрүүдийг нь танасан. Ойн 5-р бригадын 40,3 хүн өдөр хүн хүчээр 2249 ширхэг 80 см X 80 см X 80 см хэмжээтэй ойн зурвасын том мод тариалах нүх ухуулаад өмнөх сард ухсан байсан ба дээрх ухсан нүхнүүдэд 5040 ширхэг улиас, хайлаасыг тус бригадын 36,8 хүн өдөр хүч зарцуулан тариалалт хийлгэсэн. Ойн 5-р бригадын 45 хүн өдөр хүн хүчээр 30742 м урт усалгааны шуудууг засаж гаргаад 66 хүн өдөр хүчээр 45165 м урт усалгааны шуудуугаар ойн зурваст тариалсан шуудуугаар услах боломжтой хэсгийн мододыг усласан. Харин шуудуугаар услах боломжгүй хэсгийг дараах аргуудаар усласан. Усалгааны юүлэх шуудууны ирмэгээр тариалсан ойн зурвасын 12945 ширхэг моддыг 95 хүн өдөр хүч зарцуулан хувингаар зөөж усласан бол тракторын чиргүүлэн ёмкостиор услагддаг 2786 м урт усалгааны шуудуутай хэсгийг 2 хүн өдөр хүч зарцуулан усласан.

Өмнө нь ашиглах боломжгүй байсан 1-р жигүүрийг энэ жил засварлан ашиглалтанд оруулсан бөгөөд 3-р бригадын 19 хүн өдөр хүчээр 1А талбайд 3733 ширхэг мод тариалах нүх ухаад, мөн талбайд 21 хүн өдөр хүчээр 5304 ширхэг суулгацыг тариалсан.

5-р сард 2-р бригадын 11 хүн өдөр хүчээр Ротаригийн хүлэмжний 66 м<sup>2</sup> талбайн хөрсийг шигшиж, хүлэмжинд дэвсээд ухаад, 10,5 хүн өдөр хүчээр 399 хүлэмжний нурууны хөрсийг гишгэж эргүүлэн хагалаад, 19 хүн өдөр хүч зарцуулан 575,3 нурууны талбайд гацуур, нарс, шинэсний үрийг тус тус тариалсан. Мөн 2-р бригадын 49 хүн өдөр хүн хүчээр 1737 хайрцагны гүн сийрүүлэлтийг хийлгэсэн. Мөн 3-р бригадын 4,5 хүн өдөр хүчийг Ротаригийн хүлэмжний 151 нурууны хөрсийг гишгэж эргүүлэн хагалах, хар шороо зөөх ажилд зарцуулсан.

05-р сард жимст цэцэрлэгийн талбайн нөхөн тариалалтын ба тендерийн суулгац гаргах ажилд 1-р бригад 16,5 хүн/өдөр хүчээр 18549 ширхэг суулгацыг 82,5 хайрцагнаас, 4-р бригад 37 хүн/өдөр хүчээр 39830 ширхэг суулгацыг 209,4 хайрцагнаас, ойн 5-р бригад 13,5 хүн/өдөр хүчээр 3205 ширхэг суулгацыг 14 хайрцагнаас буюу нийтдээ 67 хүн/өдөр хүчээр 61584 ширхэг суулгацыг 306 хайрцагнаас ухаж гарган нийлүүлсэн.

05-р сард 3-р бригадын 23,5 хүн өдөр хүчээр 4900 м урт мод тариалсан шуудууны 1-р зэрлэгийг авахуулсан.

06-р сард мод тоолох, Ротарийн хүлэмжинд хүлэмж хучих, хүлэмжний хар тор татах, бууц ачиж буулгах зэрэг цагийн ажилд 1-р бригадын 19 хүн өдөр хүч, 3-р бригадын 9 хүн өдөр хүч, 4-р бригадын 39 хүн өдөр хүч, ойн 5-р бригадын 6 хүн өдөр хүч буюу нийт дүнгээрээ 83 хүн өдөр хүч зарцуулсан. Мөн Ротаригийн хүлэмжинд ойн 5-р бригадын 6 хүн өдөр хүчээр 18,2 м<sup>3</sup> хэмжээтэй хар шороог шигшиж, хүлэмжинд зөөж аваачин дэвссэн.

6-р сард 2-р бригадын 23 хүн/өдөр хүчээр хүлэмжний засвар, усалгаа хийлгэсэн. Мөн 25,6 хүн/өдөр хүчээр хүлэмжний гүзээлзгэний талбайд арчилгаа, 3 хүн/өдөр хүчээр гүзээлзгэнэ тариалсан ил талбайн 1210 м<sup>2</sup> хэмжээтэй талбайн зэрлэгийг гараар авах ажилбар, 1 хүн/өдөр хүчээр ил талбайн гүзээлзгэний талбайд усалгааг насадка ашиглан хийлгэсэн ба 12 хүн/өдөр хүчээр хүлэмжний 292 нурууны гүзээлзгэний зэрлэгийг гараар авах ажилбарыг, 4 хүн/өдөр хүчээр олон төрлийн модны талбайд арчилгаа хийлгэсэн. 7,5 хүн/өдөр хүчээр олон төрлийн модны талбайд 4505 модонд тогооны гүн сийрүүлэлт, 6 хүн/өдөр хүчээр мөн талбайд усалгаа хийлгэсэн. Мөн тус бригадын 1,5 хүн/өдөр хүчээр 37 мөрний усалгааны системийг угсарч усалгаа хийлгэсэн. Тус 2-р бригадын 2 хүн/өдөр хүч ашиглан 37 мөрний усалгааны системийн шон төмөр хураах, бойжуулгын талбайг бордох бууц ачиж буулгах ажил, 1 хүн/өдөр хүчээр бууцан бордоо исгэх 80 см X 150 см X 200 см хэмжээтэй нүх ухуулах зэрэг ажлууд хийлгэсэн.

06-р сард 2-р бригадын хариуцсан бойжуулгын талбайд тус бригадын 82,1 хүн/өдөр хүчээр хайрцагны гүн сийрүүлэлтийн ажилбар, 9 хүн/өдөр хүчээр 66 хайрцагт суулгацын таналтын ажилбар, 6 хүн/өдөр хүчээр 115,8 хайрцагт хамар шуудууны зэрлэгийг гараар зулгааж авах ажилбар, 38,33 хүн/өдөр хүчээр 927 хайрцагт хайрцагны доторх мөр хоорондын зэрлэгийг гараар зулгааж устгах ажилбар, 39,3 хүн/өдөр хүчээр 4401,5 хайрцагт хайрцагтай суулгацын гуравдугаар усалгааг тус тус хийлгэсэн.

06-р сард 1-р бригадын 340 хүн өдөр хүчээр хариуцсан талбайнхаа 513136 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийсэн. 2-р бригадын 6 хүн өдөр хүчээр олон төрлийн жимсний 3784 модыг хувингаар тогоонд нь усалсан ба 60,5 хүн өдөр хүчээр 35000 м урт эх цэцэрлэгийн усалгааны туслах шуудууг засаж сэргээгээд 31,9 хүн өдөр хүчээр 73884 м урт усалгааны шуудуугаар эх цэцэрлэгт усалгаа хийлгэсэн. 3-р бригадын 79 хүн өдөр хүчээр 185240 м урт усалгааны туслах шуудуугаар жимст цэцэрлэгт усалгаа хийлгэсэн. 4-р бригадын 56 хүн өдөр хүчээр 17920 м урт усалгааны шуудууг гараар сэргээлгэн ухуулж гаргуулаад 249,3 хүн өдөр хүчээр 343950 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. Тус бригадын 23 хүн өдөр хүчээр 13625 ширхэг моддод үзлэг хийж хатсан ба шимэгч мөчрүүдийг нь танасан. Ойн 5-р бригадын 110 хүн өдөр хүчээр 87274,3 м урт усалгааны шуудуугаар усалгаа хийсэн.

Ойн зурвасын 5-р бригадын 7 хүн өдөр хүч зарцуулан 1249 ойн зурвасын моддыг хувингаар зөөж усалсан.

06-р сард 1-р бригадын 7,3 хүн өдөр хүчээр 10,64 м<sup>3</sup> хэмжээтэй хүлэмжний ул шороог, 2-р бригадын 22,1 хүн өдөр хүчээр 43,47 м<sup>3</sup> хэмжээтэй хүлэмжний ул шороог, 3-р бригадын 15,3 хүн өдөр хүчээр 26,84 м<sup>3</sup> хэмжээтэй хүлэмжний ул шороог, 4-р бригадын 6,3 хүн өдөр хүчээр 9 м<sup>3</sup> хэмжээтэй хүлэмжний ул шороог, ойн 5-р бригадын 29 хүн өдөр хүчээр

69,84 м3 хэмжээтэй хүлэмжний ул шороог, буюу нийт дүнгээрээ 80 хүн өдөр хүчээр энэ жил ногоон мөчир тариалах урд 20 хүлэмжний 159,79 м3 хэмжээтэй хүлэмжний ул шороог хүрээр ухаж хүлэмжнээс шуудайлан гаргаж тракторт ачин зөөж асгасан. 1-р бригадын 7,3 хүн өдөр хүчээр 15,4 м3 хэмжээтэй хүлэмжний хайргыг, 2-р бригадын 22,1 хүн өдөр хүчээр 57 м3 хэмжээтэй хүлэмжний хайргыг, 3-р бригадын 15,3 хүн өдөр хүчээр 34,82 м3 хэмжээтэй хүлэмжний хайргыг, 4-р бригадын 6,3 хүн өдөр хүчээр 13,57 м3 хэмжээтэй хүлэмжний хайргыг, 5-р бригадын 29 хүн өдөр хүчээр 76,8 м3 хэмжээтэй хүлэмжний хайргыг буюу нийт дүнгээрээ 80 хүн өдөр хүчээр ногоон мөчир тариалах хүлэмжний 197,59 м3 хэмжээтэй хайргыг хүрээр ухаж гарган шигшсэн. Мөн 1-р бригадын 7,3 хүн өдөр хүчээр 44,9 м3 хэмжээтэй хүлэмжний хар шороог, 2-р бригадын 22,7 хүн өдөр хүчээр 47,8 м3 хэмжээтэй хүлэмжний хар шороог, 3-р бригадын 15,3 хүн өдөр хүчээр 39,17 м3 хэмжээтэй хүлэмжний хар шороог, 4-р бригадын 6,3 хүн өдөр хүчээр 40,13 м3 хэмжээтэй хүлэмжний хайргыг, 5-р бригадын 32 хүн өдөр хүчээр 59,22 м3 хэмжээтэй хүлэмжний хайргыг буюу нийт дүнгээрээ 83,6 хүн өдөр хүчээр 231,22 м3 хэмжээтэй хүлэмжний хар шороог хүрээр ухаж гарган шигшсэн.

06-р сард 1-р бригадын 31 хүн өдөр хүчээр 14220 м урт мод тариалсан шуудууны, 2-р бригадын 74,5 хүн өдөр хүчээр 42900 м урт мод тариалсан шуудууны, 3-р бригадын 94 хүн өдөр хүчээр 20091 м урт мод тариалсан шуудууны, ойн зурвасын 5-р бригадын 5 хүн өдөр хүчээр 2400 м урт мод тариалсан шуудууны буюу нийт дүнгээрээ 204,5 хүн өдөр хүчээр 79611 м урт мод тариалсан шуудууны зэрлэгийг авахуулсан.

### **2017 оны “Хархорин” ХК-ийн ургац, борлуулалтын орлого**

Тайлант жил үндсэн үйлдвэрлэлээс олсон орлого: 2017 онд нийт 630,133,1 мян төгрөгийн бүтээгдэхүүн орлого авсан.

<b>№</b>	<b>Бүтээгдэхүүний нэр</b>	<b>х / нэгж</b>	<b>Тоо ширхэг</b>
<b>1</b>	Чацаргана жимс	тн	61,3
<b>2</b>	Үхрийн нүдний жимс	кг	8
<b>3</b>	Бөөрөлзгөнө жимс	кг	5,5
<b>4</b>	Гүзээлзгэнэ жимс	кг	67,2
<b>5</b>	Чацарганы суулгац	ш	163,518
<b>6</b>	Үхрийн нүдний суулгац	ш	454
<b>7</b>	Гүзээлзгэний суулгац	ш	18
<b>8</b>	Бөөрөлзгөний суулгац	ш	8
<b>9</b>	Хайлаасны суулгац	ш	30,100
<b>10</b>	Улиасны суулгац	ш	660



11	Шар хуасны суулгац	ш	120
12	Ямааны ноолуур	кг	9,4
13	Хонины ноос	кг	135
14	Сүү	л	649
15	Тараг	л	154
16	Өрөм	ш	25
17	Чацарганы шүүс	л	7428
18	Чацарганы тос	кг	220
19	Чацарганы үр	Кг	242
20	Чацарганы хальс	Кг	90

Үндсэн үйлдвэрлэлээс орлого авч байгаа бүтээгдэхүүнийг олж авах, бэлтгэхтэй холбогдож 1,611,831,6 мян төгрөгийн зардал гарсан. Задаргааг дараах хүснэгтээс үзнэ үү:

Зардлын төрөл	Нийт дүн, төг
Мал аж ахуй	19,020,1
Засварын газар	87,181,0
Оросын жимс	325,7
Чацаргана	1,136,664,2
Ротори хүлэмж	0
Урд хүлэмж бойжуулга	64,239,6
Хамгаалалтын алба	48,712,3
Ус суваг	36,982,0
Овьёос	0
Ойн зурвас	1,343,1
Царгас	104.3
Барилга	6.640.1
Удирдлага /ЗАА/	210,619,2
<b>Зардлын дүн</b>	<b>1,611,831,6</b>

Тайлант жилийн Борлуулалтын нийт орлого: 1,219,794.3 мян төг  
 Борлуулалтын нийт өртөг : 975,970.9 мян төг  
 Борлуулалтын ашиг : 243,823.4 мян төг  
 Үйл ажиллагааны бус орлого: 3,593.0 мян төг

Үүнээс удирдлагын зардал : 210,619.2 мян. төгрөгийг хасч тооцоод 36,797.2 мян. төгрөгийн татварын өмнө ашигтай ажилласан. ААН-ийн орлогын албан татварт 3,197.5 мян төг тооцогдож татварын дараах цэвэр ашиг 33,599,. мян төгрөг болсон.

2017 онд байгаль цаг уурын хүндрэлтэй байдлаас шалтгаалж (бороо , хур ороогүйгээс) 768 тн ургац авахаар төлөвлөсөн боловч 61,3 тн ургац хураан авч үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хувьд алдагдалтай ажилласан болно,

## **11. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр:**

### *11.1. “Хархорин” ХК-ийн 2018 оны н Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухайд*

“Хархорин” ХК нь 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хуралдуулахаар болсон. Тус хурлын мэдэгдэлтэй та бүхэн МХБ-ийн цахим хуудаснаас танилцаж болно. Хурлаас гарсан шийдвэрүүдийн талаар хурал хуралдасны дараагаар МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх болно.

### *11.2. “Хархорин” ХК-ийн 2017 онд хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухайд:*

“Хархорин” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2017 оны 04-р сарын 22-ны өдөр Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах өөрийн байранд, хурлын танхимд хуралдуулсан.

Тус хурлыг зарлан хуралдуулах асуудлыг компанийн ТУЗ 2017 оны 03-р сарын 10-ны өдрийн хурлаараа авч хэлэлцээд холбогдох шийдвэрийг гаргасан. Хурлын мэдэгдлийг 2017 оны 03-р сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

Тус ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2017 оны 04 дугаар сарын 03-ны өдрөөр тогтоож, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-с бүртгэлийн өдрөөр гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг гаргуулан авсан болно.

Тус судалгааны дагуу тус бүр нэг саналын эрх бүхий нийт 539,515 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 574 хувьцаа эзэмшигчид 2017 оны 04-р сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй байсан. Эдгээр хувьцаа эзэмшигчдээс нийт 378,332 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт 8 хувьцаа эзэмшигч тус хуралд биечлэн оролцож саналаа өгсөн болно. Хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигч гараагүй.

Хурлын ирц 70.12 хувь болсон.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд болон эдгээр асуудал тус бүрээр хуралд оролцсон саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын тоог, хувь зэргийг дараах хүснэгтээс үзнэ үү:

Д/д	Хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2016 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	378,332 (100%)	0	0
2	Компанийн 2016 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	378,332 (100%)	0	0
3	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг батлах	378,332 (100%)	0	0
4	Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	378,332 (100%)	0	0

Түүнчлэн тус хурлаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр сонгосон байгаа. Кумулятив аргаар хураасан саналын хураалтын дүнг дараах хүснэгтээс үзнэ үү:

Д/д	Хурлаар хэлэлцэх асуудал	Ирүүлсэн нийт саналын эрхийн		Хүчинтэй саналын эрхээс*	
		Тоо	хувь	Тухайн асуудлаар өгсөн саналын	
				тоо	Хувь
1	ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох	2,269,992	70.12%	-	-
1.1	П. Бишрэл			378,332	16.7 %
1.2	Л. Хосбаяр			378,332	16.7 %
1.3	П. Учрал			378,332	16.7 %
1.4	Ж. Энхтөр			378,332	16.7 %
1.5	Ц. Энх-Амгалан			378,332	16.7 %
1.6	О. Төмөрбаатар			378,332	16.7 %
2	ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох	1,134,996	70.12%	-	-
2.1	Б. Амарсанаа			378,332	33.3 %
2.2	С.Амгалан			378,332	33.3 %
2.3	Б. Бүрэн			378,332	33.3 %

\*Жич: хүчингүй саналын хуудас гараагүй болно.

“Хархорин” ХК-ийн 2017 оны 04-р сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолуудтай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас үзэж танилцах боломжтой.

Тус хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг 2017 оны 04-р сарын 25-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

## 12. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн шийдвэрүүд

2017 онд “Хархорин” ХК-ийн ТУЗ-с дараах шийдвэрүүдийг гаргасан болно:

Тогтоол, шийдвэрийн Огноо	Товч утга	Тогтоол шийдвэрийн агуулга
2017.02.17	Ногдол ашиг хуваарилахгүй тухай	ТУЗ-с Компанийн тухай хуульд заасны дагуу ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг хэлэлцээд 2016 онд ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан.
2017.02.17	Аудитын байгууллага сонгох тухай	“Хархорин” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос “Улиастай Ван Аудит” ХХК-ийг компанийн аудиторроор сонгосон.
2017.03.10	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04-р сарын 22-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэж хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталсан.
2017.05.29	ТУЗ-ийн Даргаар томилох тухай	П.Бишрэлийг ТУЗ-ийн даргаар томилсон.
2017.05.29	ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох	Б.Ганбатыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсон.
2017.05.29	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо байгуулах	ТУЗ-ийн дэргэдэл Аудитын хороог 3 гишүүнтэйгээр байгуулсан
2017.05.29	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо байгуулах	ТУЗ-ийн дэргэдэл Нэр дэвшүүлэх хороог 3 гишүүнтэйгээр байгуулсан
2017.05.29	ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо байгуулах	ТУЗ-ийн дэргэдэл Цалин, урамшууллын хороог 3 гишүүнтэйгээр байгуулсан

2017 оны 04 дүгээр сард хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинээр сонгогдсон ТУЗ нь анхны хурлаа 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хуралдуулсан болно.

Тус хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хороодын гишүүдийг шинээр томилох асуудлыг авч хэлэлцсэн.

Хурлаас дараах шийдвэрүүд гарсан болно:

1. “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн ТУЗ-ийн даргаар П.Бишрэлийг үргэлжлүүлэн томилсон.
2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Б.Ганбатыг үргэлжлүүлэн томилсон.
3. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн С.Амгаланг, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Амарсанаа, ердийн гишүүн Ц.Энх-Амгалан нарыг тус тус томилсон.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ж.Энхтөрийг, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд болох С.Амгалан, Б.Бүрэн нарыг тус тус томилсон.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн О.Төмөрбаатарыг, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд болох Б.Амарсанаа, Б.Бүрэн нарыг тус тус томилсон.

### 13. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

“Хархорин” ХК-ийн 5% ба үүнээс илүү хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд тайлант хугацаанд буюу 2017 онд өөрчлөлт ороогүй болно.

5% ба үүнээс дээш хувьцаа эзэмшигчид, 2018 оны 03-р сарын 30-ны өдрийн байдлаар “ҮЦГХТ” ХХК-с гаргуулан авсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалганы дагуу:

Д.д	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь
1	С.Пүрэв	377,660 (70.00%)
2	Л.Хосбаяр	101,634 (18.84%)
3	Бусад жижиг хувьцаа эзэмшигчид (нийт 574)	60,221 (11.16%)
	ДҮН	539,515 (100%)

“Хархорин” ХК, 2018 он